



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/199

Улаанбаатар хот

Шөнийн хугацааны мэдээг
автоматаар кодлох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дэх хэсэг, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан бичгээр ирүүлсэн саналыг нь үндэслэн Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн "Төвшрүүлэх" цаг уурын өртөө, Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн "Хөхнуур" цаг уурын өртөө, Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн "Шаазгайт" цаг уурын өртөө, Сүхбаатар аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн "Дарьганга" цаг уурын өртөө, Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн "Алтанбулаг" цаг уурын өртөө, Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн "Өндөрхангай" цаг уурын өртөө, Өмнөговь аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн "Манлай" цаг уурын өртөөдийн шөнийн хугацааны 23, 02, 05 цагийн автомат станцын мэдээг 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 23 цагаас эхлэн OWL /Overnight Weather Lookout/ программыг ашиглан "Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих систем" рүү дамжуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Технологи, инновацийн хэлтэс (А.Батболд)-т даалгасугай.

2. Программ хангамж ашиглан автоматаар кодлож, дамжуулах хугацаанд цаг уурын автомат станцын хэвийн үйл ажиллагааг хангах, өртөөдийн ажиглалтын талбайг камержуулах, эрчим хүчний нөөц эх үүсвэрийг бэлтгэх, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл ажиглагдах нөхцөл бүрдсэн үед өртөөний техникч нарыг шөнийн хугацаанд ажиллуулах болон ээлжийн ажилчдын ажлын цагийг оновчтой төлөвлөж ажиллахыг аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын сүлжээний хэлтэс (Д.Уламбаяр)-т даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

151250503